

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ХУУЛИЙН ХЭЛТЭС**

**ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ
ТУХАЙ ХУУЛЬД ОРСОН НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААР**

2020 он

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

/Нэмэлт, өөрчлөлт/

Нэг. Оршил

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн даган мөрдөнө.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль нь 4 бүлэг, 29 зүйлтэй.

Хоёр. Хуулийн агуулга

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.3.6-д “Гэрч, хохирогчийн аюулгүй байдал, нууцлалыг хамгаалах чиглэлээр эрх зүйн орчинг боловсронгуй болгож, гэрч, хохирогчийн хамгааллын цогц механизмыг бүрдүүлнэ.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 45-д “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж, 2018 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх”- ээр тус тус тусгасан.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалын дагуу хийсэн үнэлгээг үндэслэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дараахь хэрэгцээ, шаардлага тулгарсан. Үүнд:

1.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг Монгол Улсын Их Хурлаас эрх зүйн шинэтгэлийн хүрээнд баталсан эрүүгийн багц хуулиудтай уялдуулж нийцүүлэх.

2.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн зарим зохицуулалт уялдаа холбоогүй, ойлгомжгүй, зарим зохицуулалт дутуу орхигдуулсан, хуульд давхардал, хийдэл, зөрчил үүссэн зэргээр практикт хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл учирсан. Тухайлбал,

-Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан хамгаалалтын арга хэмжээний төрөлд сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг оруулсан хэдий ч хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтад тодорхойлсон “хамгаалалтын арга хэмжээ” гэсэн нэр томъёоны тодорхойлолтод сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг орхигдуулсан нь энэхүү арга хэмжээг хамгаалалтын арга хэмжээ гэж ойлгох боломжгүй байдалд хүргээд байсан. Түүнчлэн сэтгэл зүйн арга хэмжээг аюулгүй байдлын арга хэмжээтэй хамтатган хэрэгжүүлэх талаарх хуулийн тодорхой зохицуулалт байхгүй, уг арга хэмжээг хэрэглэх шийдвэр гаргах субъект тодорхойгүй байсан.

-Хамгаалалт авсан гэрч, хохирогчийн мэдээллийн сан байгуулах, улсын хэмжээнд нэгдсэн тоо бүртгэл хөтлөх асуудлыг хуульчлаагүй, зарим хэлбэрийн хамгаалалтын арга хэмжээний мэдээллийн сан бүрдүүлэх асуудлыг журмаар зохицуулж байгаа нь хэрэгждэггүй, энэ нь улсын хэмжээнд нэгдсэн дүн мэдээ гаргахад судалгаа, тооцоо бодит биш байх зэрэг сөрөг үр дагаврыг бий болгохоор байлаа.

-Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан хамгаалалтад авагдсан гэрч, хохирогчид үзүүлэх туслалцаанд нийгмийн бусад тусламж үйлчилгээ үзүүлэх асуудлыг хуульчлан тусгах шаардлагатай байгаа бөгөөд ингэснээр дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх төсвийг хэрэгжүүлэгч байгууллагын

төсөвт тусгуулах боломж бүрдэх ач холбогдолтой юм. Дээрх зардалд зарцуулагдах хөрөнгийг төсөвт тусгаагүйгээс хамгаалах байраар хамгаалагдаж байгаа гэрч, хохирогчийн хоол хүнс, нийгмийн болон ахуйн хэрэгцээ шаардлагыг хангах асуудлыг шийдвэрлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсч байсан.

3.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах ажлыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хуулийг хэрэгжүүлэх байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэн зохицуулах, чиг үүрэг бүхий орон тооны бус нэгжийг бий болгох шаардлагатай байсан.

4.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг холбогдох бусад хуультай уялдуулах дараахь хэрэгцээ, шаардлага үүссэн.

-Иргэний бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсэгт “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хоригдол, хорих ял эдэлж байсан хүний овог, эцгийн нэр, нэр өөрчлөхийг хориглоно.” гэж заасан нь Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтад заасан баримт бичгийг солих хамгаалалтын арга хэмжээг хорих ял эдэлж буй гэрч, хохирогчид /сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хоригдож буй хүн, ялтан, хорих ял эдэлж байсан хүн/ хэрэглэх шаардлага бий болох тохиолдолд энэхүү заалт нь зөрчигдөхөөр байсан.

Түүнчлэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасан мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний хүрээнд нууцалбал зохих мэдээлэлд “хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэл”-ийг, хуулийн 11.2-д заасан шийдвэрийг гаргахдаа гэрч, хохирогчоос гадна шаардлагатай бол “хамаарал бүхий этгээдийн” мэдээллийг тус тус нууцлах асуудлыг орхигдуулсан нь хамгаалалтад байгаа иргэний мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ бүрэн дүүрэн хангагдахгүй, нууцлал алдагдах, цаашлаад гэрч, хохирогчийн амь нас эрүүл мэндэд хохирол учрах эрсдэл үүсэх нөхцөл байдал бий болжээ.

-Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 10.1-д заасан хамгаалалтыг төрийн тусгай хамгаалалт, зэвсэгт хүчин, бусад цэрэг, тагнуул, цагдаагийн харуул хамгаалалтын бүсэд хэрэгжүүлж болно.” гэсэн заалтыг хэрэгжүүлэхийн тулд Зэвсэгт хүчний тухай хууль болон холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулахгүйгээр хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 230 дугаар зүйлийн 230.5 дахь хэсэгт “Хорих анги, хорих ангийн алба хаагч Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан журмын дагуу хамгаалалтад авсан хоригдлыг хамгаалах ажиллагаанд бүх талын туслалцаа үзүүлэх үүрэгтэй” гэж заасан боловч Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд цагдан хорих байранд хоригдож байгаа болон хорих ял эдэлж буй гэрч, хохирогчийг хамгаалах, аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар хуулийн зохицуулалт тодорхойгүйгээс хэрэгжүүлэхэд учир дутагдалтай байсан.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд дараахь асуудлыг тусгажээ. Үүнд:

1.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах ажлыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, чиг үүрэг бүхий нэгжийг бий болгох, хуулийн зарим тодорхойгүй зохицуулалтыг холбогдох хуультай уялдуулах, мөн сэтгэл зүйн арга хэмжээг хамгаалалтын арга хэмжээ болгох, нийгмийн бусад тусламж үйлчилгээ үзүүлэх асуудал болон хамгаалалтад авсан гэрч, хохирогчийн талаар мэдээллийн сан үүсгэхтэй холбоотой шинээр бүлэг, хэсэг, заалт нэмсэн.

2.Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх шийдвэр гаргах субъектийг тодорхой болгох, гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах,

баримт бичгийг солих хамгаалалтын арга хэмжээнд хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийг оруулахтай холбоотой нэмэлт оруулжээ.

3.Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой шаардлагатай төсвийг тодорхой болгох, хуулийн зарим зохицуулалтыг Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нийцүүлэн өөрчлөн найруулсан.

4.Зарим нэр томьёог Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нийцүүлэн томьёолох, сэтгэл зүйн арга хэмжээг хамгаалалтын арга хэмжээ болгож байгаатай холбогдуулан зарим зүйл, хэсэг, заалтын нэр томьёонд өөрчлөлт оруулсан.

5.Шаардлагагүй, ач холбогдолгүй болон давхардал, хийдэл, зөрчил үүсгэсэн асуудлыг арилгах зорилгоор зарим зүйл заалтаас үг өгүүлбэр хасах, зарим зохицуулалтыг хүчингүй болгох зохицуулалтыг тусгасан.

Монгол Улсын Их Хурлаас эрх зүйн шинэтгэлийн хүрээнд баталсан эрүүгийн багц хуулиудтай нийцэж, гэрч, хохирогчийг хамгаалах хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд гарч буй хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчил арилж хуулийг нэг мөр хэрэгжүүлэх боломж бүрдэнэ гэж хууль санаачлагч үзэж тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Монгол Улсын хууль тогтоох дээд байгууллагад өргөн мэдүүлж, Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар батлагдсан учир цагдаа, дотоодын цэргийн байгууллага, алба хаагчид хамаарах нэмэлт, өөрчлөлт оруулсан зүйл, заалтаас түүвэрлэн энэхүү мэдээллийг боловсрууллаа.

Хуулийг <https://legalinfo.mn/law/details/9287> холбоосоор орж дэлгэрэнгүй үзнэ үү.

---oOo---

ГАРЧИГ

Нэг. Оршил

Хоёр. Хуулийн агуулга

Гурав. Хуулийн зарим зохицуулалтаас

Дөрөв. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу дагалдан гарах эрх зүйн актууд

ГУРАВ:ХУУЛИЙН ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТААС

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуулийн зохицуулалт
Энэ хуулийн зорилт нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг тогтооход оршино.	Энэ хуулийн зорилт нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг тогтооход оршино.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр өөрчлөлт оруулсан хуулийн зохицуулалт	2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуулийн зохицуулалт
1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно: 4.1.2."хамгаалалтын арга хэмжээ" гэж энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг	1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно: 4.1.2."хамгаалалтын арга хэмжээ" гэж энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэнд болон сэтгэл зүйг хамгаалах арга хэмжээг
4.1.3."эрх бүхий албан тушаалтан" гэж энэ хуульд заасан гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэр гаргах албан тушаалтныг /шүүгч, прокурор, мөрдөгч/.	4.1.3."эрх бүхий албан тушаалтан" гэж хуульд заасан гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэр гаргах албан тушаалтныг /шүүгч, прокурор, мөрдөгч/.
Сэтгэл зүйн арга хэмжээг аюулгүй байдлын арга хэмжээтэй хамтатган хэрэгжүүлэх талаарх хуулийн тодорхой зохицуулалт байхгүй, уг арга хэмжээг хэрэглэх шийдвэр гаргах субъект тодорхойгүй байсан учир нэмж тусгасан.	

5 дугаар зүйл.Хуулийн зохицуулалтад хамаарах этгээд

2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуулийн зохицуулалт
-	4.Гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт сэлт өгөх болон бусад байдлаар туслалцаа үзүүлсэн, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр оролцоогүй хүн энэ хуульд хамаарагдаж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ, ТУСЛАЛЦАА

8 дугаар зүйл.Урьдчилан сануулах

2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр өөрчлөлт оруулсан хуулийн зохицуулалт	2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуулийн зохицуулалт
Гэрч, хохирогчийг алах, бие махбодид гэмтэл учруулах, тарчлаах, айлган сүрдүүлэх, дарамтлах, мөнгө, эд зүйл амлах болон бусад гэмт хэргийг үйлдэхээр заналхийлсэн нь тогтоогдвол тухайн этгээдэд хүлээлгэх ял	1.Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд халдахаар заналхийлбэл тухайн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар шүүгч, прокурор, мөрдөгч бичгээр урьдчилан сануулж, гарын

шийтгэлийн талаар шүүгч, прокурор, мөрдөгч бичгээр урьдчилан сануулж, гарын үсэг зуруулна.	үсэг зуруулна. /Өөрчлөн найруулсан/
--	--

9 дүгээр зүйл.Тодорхой үйлдлийг хязгаарлах

2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуулийн зохицуулалт
1.Тодорхой үйлдлийг хязгаарлах арга хэмжээнд гэрч, хохирогчтой уулзах, харилцах, харилцаа тогтоохыг оролдох, дагаж мөшгих болон бусад хэлбэрээр харилцахыг хориглох арга хэмжээ хамаарна.	1.Тодорхой үйлдлийг хязгаарлах арга хэмжээнд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид гэрч, хохирогчтой уулзах, харилцах, харилцаа тогтоохыг оролдох, дагаж мөшгих болон бусад хэлбэрээр харилцахыг хориглох арга хэмжээ хамаарна.

11 дүгээр зүйл.Мэдээллийн нууцлалыг хангах

2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуулийн зохицуулалт
1.Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газар, өмчлөлд нь байгаа үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл, харилцах утасны дугаар болон тээврийн хэрэгслийн улсын дугаар зэрэг мэдээллийн нууцлалыг хангах арга хэмжээ авна. Шаардлагатай тохиолдолд гэрч, хохирогчийн хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, иргэний улсын бүртгэлийн талаарх мэдээлэлд өөрчлөлт оруулах, халхагч нэр хэрэглэх, харилцах утасны дугаар болон тээврийн хэрэгслийн улсын дугаарыг өөрчлөх зэрэг арга хэмжээг эрх бүхий албан тушаалтан холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.	1.Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газар, өмчлөлд нь байгаа үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл, харилцах утасны дугаар болон тээврийн хэрэгслийн улсын дугаар зэрэг мэдээллийн нууцлалыг хангах арга хэмжээ авна. Шаардлагатай тохиолдолд гэрч, хохирогчийн хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, иргэний улсын бүртгэлийн талаарх мэдээлэлд өөрчлөлт оруулах, зохиомол нэр хэрэглэх, харилцах утасны дугаар болон тээврийн хэрэгслийн улсын дугаарыг өөрчлөх зэрэг арга хэмжээг эрх бүхий албан тушаалтан холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
2.Эрх бүхий албан тушаалтан иргэний бүртгэлийн, автотээврийн болон бусад байгууллагын мэдээлэл, лавлагааны сангаас хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн хувийн мэдээллийг задруулахыг түр хугацаагаар хориглох шийдвэр гаргаж болно.	2.Эрх бүхий албан тушаалтан иргэний бүртгэлийн, автотээврийн болон бусад байгууллагын мэдээлэл, лавлагааны сангаас хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн болон хамаарал бүхий этгээдийн хувийн мэдээллийг задруулахыг түр хугацаагаар хориглох шийдвэр гаргаж болно.
3.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой онцгой тохиолдолд, эсхүл Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх явцад хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн талаарх мэдээлэл авах хүсэлтээ Үндсэн хуулийн цэц болон шүүх эрх мэдлийн байгууллагад бичгээр гаргана.	3.Гэрч, хохирогчийн нууцлал зохих мэдээллийг Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий албан тушаалтанд танилцуулж болно. /Өөрчлөн найруулсан/

Гэрч, хохирогчоос гадна шаардлагатай бол “хамаарал бүхий этгээдийн” мэдээллийг тус тус нууцлах асуудлыг орхигдуулсан нь хамгаалалтад байгаа иргэний мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ бүрэн дүүрэн хангагдахгүй, нууцлал алдагдах, цаашлаад гэрч, хохирогчийн амь нас эрүүл мэндэд хохирол учрах эрсдэл үүсэх нөхцөл байдал бий болж байсан учир “хамаарал бүхий этгээдийн” гэж шинээр нэмж тусгасан.

12 дугаар зүйл.Хувийн хамгаалалтын хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах

2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуулийн зохицуулалт
2.Тусгай техник хэрэгслийн жагсаалт, хэрэглэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хүчингүй болсонд тооцсон.

13 дугаар зүйл.Аюулгүй газарт түр байрлуулах

2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуулийн зохицуулалт
1.Шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан насанд хүрсэн гэрч, хохирогчийг өөрийнх нь зөвшөөрснөөр, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч эсхүл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зөвшөөрснөөр аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулна.	1.Шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан насанд хүрсэн гэрч, хохирогчийг өөрийнх нь зөвшөөрснөөр, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч , эсхүл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зөвшөөрснөөр аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулна.
-	2.Насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах асуудлыг нарийвчлан зохицуулсан стандартыг холбогдох байгууллагаар батлуулан мөрдөж ажиллана. <i>/Шинээр нэмсэн/</i>

15 дугаар зүйл.Баримт бичгийг солих

2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуулийн зохицуулалт
-	2.Гэрч, хохирогчийн баримт бичгийг солих аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээнд дараах баримт бичгийн өөрчлөлт хамаарна: 2.4.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ; <i>/Шинээр нэмсэн/</i>
-	4.Солигдсон баримт бичгийг Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасны дагуу хадгалж, хамгаалах бөгөөд баримт бичгийг солих нөхцөл байдал арилсан тохиолдолд тухайн этгээдийн хүсэлтийн дагуу солигдсон баримт бичгийг сэргээж, өөрчлөлт оруулах асуудлыг энэ хуулийн 21.5-д заасан журмын дагуу хэрэгжүүлнэ. <i>/Шинээр нэмсэн/</i>

16 дугаар зүйл.Гадаад төрхийг өөрчлөх

2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуулийн зохицуулалт
4.Энэ хуулийн 16.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх бөл тухайн гэрч, хохирогчийн гэмт хэрэгт хөлбөгдөж байсан эсэх талаарх лавлагааг хөлбөгдөх байгууллагаас авна.	Хүчингүй болсонд тооцсон.

17 дугаар зүйл.Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ

2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуулийн зохицуулалт
-	4.Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээтэй хамт хэрэгжүүлж болно. /Шинээр нэмсэн/

18 дугаар зүйл.Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид үзүүлэх туслалцаа

2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуулийн зохицуулалт
-	1.Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид дараах туслалцаа үзүүлж болно: 1.4.нийгмийн бусад туслалцаа. /Шинээр нэмсэн/
4.Энэ хуулийн 18.1.1-д заасан хууль зүйн болон 18.1.2-т заасан сэтгэл зүйн туслалцааг энэ хуулийн 23.4-т заасан нээж тус тус хариуцан хэрэгжүүлнэ.	4.Энэ хуулийн 18.1.1-д заасан хууль зүйн болон 18.1.2-т заасан сэтгэл зүйн туслалцааг энэ хуулийн 23.4-т заасан алба тус тус хариуцан хэрэгжүүлнэ.
-	Тайлбар: Энэ хуульд заасан “нийгмийн бусад туслалцаа” гэж хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн амьдралын зайлшгүй хэрэгцээт хоол хүнс, хувцас, шаардлагатай бусад ахуйн хэрэгцээ болон насанд хүрээгүй гэрч, хохирогчийн суралцах хэрэгцээг хангахад чиглэсэн төрөөс үзүүлж байгаа тусламж үйлчилгээг ойлгоно. /Шинээр нэмсэн/
Хамгаалалтад авагдсан гэрч, хохирогчид үзүүлэх туслалцаанд нийгмийн бусад тусламж үйлчилгээ үзүүлэх асуудлыг хуульчлан тусгах шаардлагатай байгаа бөгөөд ингэснээр дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх төсвийг хэрэгжүүлэгч байгууллагын төсөвт тусгуулах боломж бүрдэх ач холбогдолтой юм. Дээрх зардалд зарцуулагдах хөрөнгийг төсөвт тусгаагүйгээс хамгаалах байраар хамгаалагдаж байгаа гэрч, хохирогчийн хоол хүнс, нийгмийн болон ахуйн хэрэгцээ шаардлагыг хангах асуудлыг шийдвэрлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсч байсан учир шинээр нэмж тусгасан.	

ГУРАВДУГААР БҮЛЭГ ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ҮНДЭСЛЭЛ, ЖУРАМ

20 дугаар зүйл. Хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх, цуцлах үндэслэл

2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуулийн зохицуулалт
1.Аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх үндэслэл нь гэрч, хохирогчийн хүсэлт, эсхүл өмгөөлөгч, мөрдөгч, прокурор, шүүгчийн бичгээр гаргасан санал байна.	1.Хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх үндэслэл нь гэрч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн бичгээр гаргасан хүсэлт, мөрдөгч, прокурорын бичгээр гаргасан санал байна. /Өөрчлөн найруулсан/
2.Хамгаалалтын арга хэмжээг дараах үндэслэлээр цуцална: 2.1.хамгаалалтад байгаа гэрч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн бичгээр гаргасан хүсэлт, мөрдөгч, прокурорын бичгээр гаргасан санал; 2.2.аюулгүй байдлын хамгаалалт	2.Хамгаалалтын арга хэмжээг дараах үндэслэлээр цуцална: 2.1.хамгаалалтад байгаа гэрч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн бичгээр гаргасан хүсэлт, мөрдөгч, прокурорын бичгээр гаргасан санал; 2.2.хамгаалалт хэрэглэх шийдвэр гаргасан албан тушаалтан, эсхүл түүний дээд

хэрэглэх шийдвэр гаргасан албан тушаалтан, эсхүл түүний дээд шатны албан тушаалтны шийдвэр.	шатны албан тушаалтны шийдвэр.
3.Энэ хуулийн 20.2.2-т заасан албан тушаалтан дараах үндэслэлээр аюулгүй байдлын хамгаалалтыг цуцлах шийдвэр гаргана: 3.2.хамгаалуулагч нь аюулгүй байдлын хамгаалалтын шаардлага, арга хэмжээг санаатайгаар удаа дараа зөрчсөн.	3.Энэ хуулийн 20.2.2-т заасан албан тушаалтан дараах үндэслэлээр хамгаалалтыг цуцлах шийдвэр гаргана: 3.2.хамгаалуулагч нь хамгаалалтын шаардлага, арга хэмжээг санаатайгаар удаа дараа зөрчсөн.
-	4.Хамгаалалтын арга хэмжээг цуцлах шийдвэр гаргахад энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан нөхцөлийг харгалзан үзнэ. <i>/Шинээр нэмсэн/</i>
-	5.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд мөрдөгчийн бичгээр гаргасан санал, шүүхийн шатанд прокурорын бичгээр гаргасан саналын дагуу хамгаалалтын арга хэмжээг авахад гэрч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгчийн саналыг авсан байна. <i>/Шинээр нэмсэн/</i>

21 дүгээр зүйл.Хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам

2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуулийн зохицуулалт
1.Эрх бүхий албан тушаалтан гэрч, хохирогчийн хүсэлт, зөвшөөрөл, бодит аюул заналхийллийн талаарх баримтыг үндэслэн энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан нөхцөлд дүн шинжилгээ хийх замаар аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх шийдвэрийг нэн даруй гаргана.	1.Эрх бүхий албан тушаалтан гэрч, хохирогчийн хүсэлт, зөвшөөрөл, бодит аюул заналхийллийн талаарх баримтыг үндэслэн энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан нөхцөлд дүн шинжилгээ хийх замаар хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх шийдвэрийг нэн даруй гаргана.
2.Дараах албан тушаалтан хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргана: 2.1.энэ хуулийн 16.2, 17.1-д заасан хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийг аюулгүй байдлын хамгаалалтад байгаа гэрч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, эсхүл түүний өмгөөлөгчийн хүсэлтээр мөрдөгч; 2.2.Энэ хуулийн 7.1.2-7.1.6-д заасан хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийг мөрдөн шалгах ажиллагаанд прокурор, шүүхийн шатанд шүүгч; 2.3.Энэ хуулийн 7.1.7, 7.1.8, 16.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх шийдвэрийг прокурор, мөрдөн шалгах болон тагнуулын байгууллагын гаргасан саналыг үндэслэн шүүгч.	2.Дараах албан тушаалтан хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргана: 2.1.энэ хуулийн 16.2, 17.1-д заасан хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийг хамгаалалтад байгаа гэрч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, эсхүл түүний өмгөөлөгчийн хүсэлтээр мөрдөгч; 2.2.энэ хуулийн 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.6, 17.1-д заасан хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд гэрч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн бичгээр гаргасан хүсэлт, мөрдөгчийн бичгээр гаргасан саналыг үндэслэн прокурор, шүүхийн шатанд прокурорын бичгээр гаргасан саналыг үндэслэн шүүгч; <i>/Өөрчлөн найруулсан/</i> 2.3.энэ хуулийн 7.1.7, 7.1.8, 16.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх шийдвэрийг гэрч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн бичгээр гаргасан хүсэлт, прокурорын бичгээр гаргасан саналыг

	үндэслэн шүүгч. /Өөрчлөн найруулсан/
3.Энэ хуулийн 7.1.7, 7.1.8, 16.1-д заасан арга хэмжээ нь аюулгүй байдлын онцгой арга хэмжээ бөгөөд эдгээрийг Мөрдөх албаны харьяалах хэргийн гэрч, хохирогчид тэдний аюулгүй байдлыг хамгаалалтын бусад арга хэмжээг хэрэглэн хамгаалж чадахгүй нөхцөлд хэрэглэнэ.	3.Энэ хуулийн 7.1.7, 7.1.8, 16.1-д заасан арга хэмжээ нь аюулгүй байдлын онцгой арга хэмжээ бөгөөд эдгээрийг мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагын харьяалах хэргийн гэрч, хохирогчид тэдний аюулгүй байдлыг хамгаалалтын бусад арга хэмжээг хэрэглэн хамгаалж чадахгүй нөхцөлд хэрэглэнэ.
5.Энэ хуулийн 7.1.3-7.1.9-д заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	5.Энэ хуулийн 7.1.3-7.1.9-д заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Энэ хуулийн 10.2-т заасан бүсэд биечилсэн хамгаалалтыг хэрэгжүүлэх журмыг батлахдаа холбогдох байгууллагын саналыг харгалзана.
7.Энэ хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг ээмт хэрээ хянан шийдвэрлэх ажиллагааны явцад авах бөгөөд шаардлагатай гэж үзвэл уг ажиллагаа дууссаны дараа үргэлжлүүлж болно.	7.Энэ хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад авах бөгөөд шаардлагатай гэж үзвэл уг ажиллагаа дууссаны дараа үргэлжлүүлж болно.
	21.8.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд энэ хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл журмыг баримтална. <i>/Шинээр нэмсэн/</i>
	21.9.Цагдан хоригдож байгаа болон хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогчийг хамгаалах журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. <i>/Шинээр нэмсэн/</i>
	21.10.Энэ хуулийн 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.6, 7.1.7, 7.1.8, 7.1.9-д заасан хамгаалалтын арга хэмжээг авахдаа хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага нь хамгаалалтад авах гэрч, хохирогч, хамтран хэрэгжүүлэх байгууллагатай гэрээ байгуулах бөгөөд гэрээний загварыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний хэлбэрээс хамаарч гэрээнд холбогдох эрх, үүрэг, хариуцлагыг тусгана. <i>/Шинээр нэмсэн/</i>
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 230 дугаар зүйлийн 230.5 дахь хэсэгт “Хорих анги, хорих ангийн алба хаагч Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан журмын дагуу хамгаалалтад авсан хоригдлыг хамгаалах ажиллагаанд бүх талын туслалцаа үзүүлэх үүрэгтэй” гэж заасан боловч Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд цагдан хорих байранд хоригдож байгаа болон хорих ял эдэлж буй гэрч, хохирогчийг хамгаалах, аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар хуулийн зохицуулалт тодорхойгүйгээс хэрэгжүүлэхэд учир дутагдалтай байсан учир шинээр нэмж тусгасан.	

22 дугаар зүйл.Хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргахад харгалзан үзэх нөхцөл

<i>2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт</i>	<i>2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуулийн зохицуулалт</i>
1.Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргахдаа эрх бүхий албан тушаалтан дараах нөхцөлийг харгалзан үзнэ:	1.Хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргахдаа эрх бүхий албан тушаалтан дараах нөхцөлийг харгалзан үзнэ:
2.Энэ хуулийн 23.4-т заасан сэтгэл зүйчийн баг нь шаардлагатай тохиолдолд хамгаалалтанд байгаа гэрч, хохирогчийн сэтгэл зүйн байдлыг тодорхойлох зорилгоор энэ зүйлийн 1.6-д заасан сэтгэл зүйн сорилыг авч, хамгаалалтын хэлбэрийг сонгох зөвлөмж гаргана.	2.Энэ хуулийн 23.4-т заасан сэтгэл зүйчийн баг нь шаардлагатай тохиолдолд гэрч, хохирогчийн сэтгэл зүйн байдлыг тодорхойлох зорилгоор энэ зүйлийн 1.6-д заасан сэтгэл зүйн сорилыг авч, хамгаалалтын хэлбэрийг сонгох зөвлөмж гаргана.

23 дугаар зүйл.Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага, түүний үүрэг

<i>2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт</i>	<i>2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуулийн зохицуулалт</i>
1. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг дараах байгууллагууд өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ: 1.2.мөрдөх алба;	1. Хамгаалалтын арга хэмжээг дараах байгууллагууд өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ: /1.2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсон/
2.Энэ хуулийн 23.1-д заасан байгууллагууд нь гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий хамгаалалтын тусгай албатай байна.	2.Энэ хуулийн 23.1-д заасан байгууллагууд нь тухайн байгууллагын даргын дэргэд гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий хамгаалалтын тусгай албатай байна.
3.Энэ хуулийн 23.2-т заасан хамгаалалтын тусгай нээж нь гэрч, хохирогчийг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ: 3.3.нүүлгэн шилжүүлэх, баримт бичиг солих, мэс заслын аргаар гадаад төрхийг өөрчлөх хамгаалалтын арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх ; 3.5.хууль зүйн туслалцаа болон бусад нийгмийн үйлчилгээ үзүүлэх; 3.6.шаардлагатай гэж үзвэл аюулгүй байдлын хамгаалалтын хэлбэрийг өөрчлөх тухай саналаа холбогдох албан тушаалтанд гаргах;	3.Энэ хуулийн 23.2-т заасан хамгаалалтын тусгай алба нь гэрч, хохирогчийг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ: 3.3.нүүлгэн шилжүүлэх, баримт бичиг солих, мэс заслын аргаар гадаад төрхийг өөрчлөх хамгаалалтын арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ; 3.5.хууль зүйн туслалцаа болон нийгмийн бусад туслалцаа үзүүлэх; 3.6.шаардлагатай гэж үзвэл аюулгүй байдлын хамгаалалтын хэлбэрийг өөрчлөх, цуцлах тухай саналаа холбогдох албан тушаалтанд гаргах; 3.9.хамгаалалтад авсан гэрч, хохирогчийн талаар мэдээллийн сан үүсгэн хөтлөх; /3.9 дэх заалтыг шинээр нэмсэн/
4.Энэ хуулийн 23.2-т заасан тусгай нээжийн дэргэд мэргэжлийн хууль зүйн зөвлөгөө өгөх болон сэтгэл зүйчийн баг ажиллана.	4.Энэ хуулийн 23.2-т заасан тусгай албаны дэргэд мэргэжлийн хууль зүйн зөвлөгөө өгөх болон сэтгэл зүйчийн баг ажиллана.
5.Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар энэ хуулийн 7.1.1-7.1.6-д заасан арга хэмжээг өөрийн харьяалах асуудлын хүрээнд хэрэгжүүлнэ.	5.Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар энэ хуулийн 7.1.1-7.1.6-д заасан арга хэмжээг өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ.

24 дүгээр зүйл.Хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийн талаар гомдол гаргах

2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуулийн зохицуулалт
1.Хамгаалалтад байгаа гэрч, хохирогч энэ хуулийн 21.2-т заасан хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийн талаар гомдол гаргах эрхтэй бөгөөд шийдвэрийг танилцуулснаас хойш 14 хоногийн дотор гомдлоо шүүхэд гаргана.	1.Хамгаалалтад байгаа гэрч, хохирогч энэ хуулийн 21.2-т заасан хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийн талаар гомдол гаргах эрхтэй бөгөөд шийдвэрийг танилцуулснаас хойш 14 хоногийн дотор гомдлоо дээд шатны прокурор болон харьяалах шүүхэд гаргана.
-	2.Шүүх болон прокурор гомдлыг ажлын таван өдрийн дотор хянаж шийдвэрлэнэ. <i>/Шинээр нэмсэн/</i>

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
БУСАД ЗҮЙД**

25 дугаар зүйл.Гэрч, хохирогчийг хамгаалах талаарх төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын хүлээх үүрэг

2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуулийн зохицуулалт
4.Шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллага болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь гэрч, хохирогчтой харьцах, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах чиглэлээр шүүгч, прокурор, мөрдөгчийг чадвар сайжруулах сургалтад хамруулж, хохирогч, гэрчтэй харьцахад баримтлах журам боловсруулж мөрдүүлнэ.	4.Шүүх, прокурор, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь гэрч, хохирогчтой харьцах, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах чиглэлээр шүүгч, прокурор, мөрдөгчийг чадвар сайжруулах сургалтад хамруулж, хохирогч, гэрчтэй харьцахад баримтлах журам боловсруулж, баталж мөрдүүлнэ.
5.Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага нь гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр энэ хуулийн 23.2-т заасан байгууллага болон эрх бүхий бусад байгууллагад туслалцаа, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.	5.Нутгийн өөрөө удирдах болон төрийн байгууллага нь гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр энэ хуулийн 23.2-т заасан байгууллага болон эрх бүхий бусад байгууллагад туслалцаа, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

25¹ дүгээр зүйл.Зөвлөл

/Шинээр нэмсэн/

2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуулийн зохицуулалт
25 ¹ .1.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах ажлыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд ажиллана.
25 ¹ .2.Зөвлөлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ахалж, бүрэлдэхүүнд нь санхүү, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мөрдөн шалгах ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий байгууллага, прокурор, шүүх, холбогдох бусад төрийн байгууллагын төлөөллөөс бүрдүүлж ажиллана.
25 ¹ .3.Энэ хуулийн 25 ¹ .2-т заасан зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж болно.
25 ¹ .4.Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

25¹.5.Зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

25¹.5.1.гэрч, хохирогчийг хамгаалах салбар дундын ажлыг уялдуулан зохицуулах;

25¹.5.2.гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг шийдвэрлэх талаар санал боловсруулах, хөтөлбөрийн биелэлтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах арга хэмжээ авах;

25¹.5.3.холбогдох яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн бус байгууллагад зөвлөмж өгөх;

25¹.5.4.гэрч, хохирогчийг хамгаалах байгууллага, албадын алба хаагчдыг сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;

25¹.5.5.иргэд, олон нийтэд хууль тогтоомжийг сурталчлах.

-----oOo-----

**ДӨРӨВ. ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД
ЗААСНЫ ДАГУУ ДАГАЛДАХ ГАРАХ ЭРХ ЗҮЙН АКТЫН ТУХАЙ**

№	Журам, зааврын нэр	Батлах субъект	Хуулийн заалт
1	Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам	Эрүүл мэндийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран	18 дугаар зүйлийн 18.3
2	Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх журам	Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	21 дүгээр зүйлийн 21.5
3	Цагдан хоригдож байгаа болон хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогчийг хамгаалах журам	Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн	21 дүгээр зүйлийн 21.9
4	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах ажлыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам	Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	25 ¹ дүгээр зүйлийн 25 ^{1.4}

----oOo----